

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог

дэмжих төсөл (DPUB)

Мэдээллийн эмхэтгэл № 9 (2018 он 3-р сар)

НҮБ дэх дадлага

НҮБ-д дадлага хийж байгаа хүмүүс нэлээд завтай байдаг. Завтай хүмүүс ч байдаг гэсэн үг л дээ. (инээв) Тухайлбал надтай ижил хугацаанд дадлага хийж байсан хүмүүс (ихэнх нь барууны орныхон) 5 цаг болонгуут гэртээ харих, зарим үед эрт тарах, амралт авахаас гадна хийх ажил бага байна гэж гомдоллох тохиолдол ч байсан. Гэхдээ энэ бүхэн хариуцсан мэргэжилтнээс нь шалтгаалдаг. Дадлага хийлгэх, ямар ажил үүрэг өгөх зэргийг мэргэжилтэн шийддэг болохоор байгууллагын хувьд зөвхөн оюутнуудыг танилцуулах л үүрэгтэй. Тиймээс хариуцсан мэргэжилтэн нь ажил үүрэг даалгахгүй байгаа тохиолдолд хийх зүйл бараг байдаггүй. Харамсалтай нь дадлагажигч оюутнуудад үүрэг даалгавар хүлээлгэдэг мэргэжилтнүүд санасныг бодвол цөөхөн байсан юм. Харин миний дадлагыг удирдаж байсан мэргэжилтнүүд болох Сан Юнва, Такаминэ Ютака нар надад их ажил даатгадаг байсан. Тийм учраас би 6 сарын хугацаанд өдөр бүр өглөө 8 цагт ажилдаа ирж, орой 8 цагт гэртээ харьдаг байлаа. Нэг удаа 8 цаг болж байтал гэнэт Юнва мэргэжилтэнд туслах ажил гарч, шөнийн 1 цагт гэртээ харьсан тохиолдол ч бий. Гэхдээ би үүний ачаар НҮБ-ын ажил, Хөгжлийн бэрхшээлийн салбарын талаар сонирхох болсон. Өөрөөр хэлбэл НҮБ гэх элит бүлэг дотор ч гэсэн ажлыг яг таг хийдэг, хийдэггүй хүн байдгийг, эцсийн дүнд бүх зүйл өөрөөс шалтгаалдаг гэдгийг сайн ойлгосон. Гэхдээ ямар ч байсан Хөгжлийн бэрхшээлийн салбарт ажилладаг хүмүүс их сонирхолтой байсан нь сэтгэлд тод дурсамж үлдээсэн! (Үргэлжлэл бий...)



DPUB төслийн ахлах зөвлөх Чича Хисао

DPUB Фэйсбүүк хуудсыг илүү хүртээмжтэй болгох талаар сургалт авлаа!

2018.02.20



Сургалтын үеэр

DPUB фэйсбүүк хуудасны мэдээллийг илүү олон хүнд хүргэх зорилгоор мэргэжлийн багш урьж, Фэйсбүүкийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар сургалт авлаа. Энэхүү сургалтаар гэртээ байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх, зургийг хэрхэн зохистой оруулах гэх мэт олон аргын талаар суралцсан юм. Мөн тус сургалтанд ЖАЙКА-ийн Нийгмийн даатгалын чадавхийг бэхжүүлэх төсөл, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, Хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төсөл, Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүд оролцож фэйсбүүкийн шинэ тохиргоо, тэдгээрийг ашиглах аргын талаар суралцлаа. Цаашид төслийн ажилчид харилцан туршлага солилцож, мэдээллийг илүү үр дүнтэй, хүртээмжтэй байдлаар түгээхийн төлөө ажиллах болно.



Цуврал хичээлийн хаалгын ажиллагаа зохион байгуулагдлаа

2018.03.05



Сертификат гардуулах үеэр

3-р сарын 5-ны өдөр 2017 оны хамгийн сүүлийн “Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуучуудад зориулсан цуврал хичээл” зохион байгуулагдлаа. Тус хичээлээр Англи, Америк, Япон, Тайланд, Филиппин улсуудын ХБИ-ийн хөдөлгөөний түүхийн талаар дахин давтаж үзсэн юм. Дараа нь төслийн ахлах зөвлөх Чича оролцогч залуучуудаас хичээлийн агуулгатай холбоотой асуулт асуусан ба оролцогчид асуултанд идэвхтэй хариулж байлаа. Хичээлийн төгсгөлд бүгдээрээ дурсгалын зураг татуулж, цуврал хичээлүүдэд бүрэн хамрагдсан манлайлагч залуучуудад сертификат гардууллаа.



JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1621** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Чингис хаан нисэх онгоцны буудлын албан хаагчдад зориулсан лекц зохион байгууллаа

2018.02.19

Яагаад нисэх онгоцны буудлын үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй болгох шаардлагатай вэ? Монголын засгийн газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон онгоцны буудлын үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй байлгах ач холбогдлын талаар тайлбарлахын тулд Чингис хаан нисэх онгоцны буудлын ажилчдад зориулан лекц уншлаа. Тус лекцэнд нийтдээ 182 албан хаагч хамрагдсан. Лекцийн өмнө тэргэнцэртэй иргэд онгоцны буудал, нисэх онгоцоор үйлчлүүлж буй “Тэргэнцэртэй зорчигч” хэмээх бичлэгийг үзүүллээ. Тус видео нь маш сайн агуулгатай бөгөөд ANA авиа компанийн жишээ гардаг тул бичлэгээс олон зүйлийг олж харах боломжтой юм. Дараа нь Монголын засгийн газрын хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлийн салбар дахь бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, ялангуяа Нийгмийн загвар, Тохирох хэрэглэгдэхүүний талаар тайлбарлалаа.

Монголын засгийн газар 2016 оны 2-р сард Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан бөгөөд одоо хуулийн хэрэгжилттэй холбоотой ажлуудыг хэрэгжүүлж байна. Тус хуулийг НҮБ-ын конвенцид тулгуурлан боловсруулсан ба өөрийн оронд Нийгмийн загварын ойлголтыг дэлгэрүүлэх, хөгжлийн бэрхшээлийнх улмаас ялгаварлан гадуурхахыг хориглох ажлуудыг эрчимтэй явуулж байна. Төслийн зүгээс Монголд айлчлан ирэх бүх хүмүүст ээлтэй онгоцны буудлын үйлчилгээг бий болгох зорилгоор цаашид ч гэсэн хамтран ажиллах болно.



Нисэх буудлын албан хаагчид



Лекцийн үеэр (нисэх буудал)

2 дахь удаагийн DET Сургагч багш бэлтгэх сургалтын бүртгэл дууслаа!

2018.02.26



Эхний төгсөлтийн DET сургагч багш нар

4-р сард зохион байгуулагдах Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын сургагч багш бэлтгэх сургалтын бүртгэлийн хугацаа дууслаа. Энэ удаа нийт 41 хүн материалаа ирүүлсэн бөгөөд ярилцлагын шалгаруулалтын дараа эцсийн байдлаар 16 хүнийг сургалтанд хамруулах болно. DET сургалтыг 5-6 хүн нэг баг болж зохион байгуулдаг. Мөн сургагч багш нарт зориулсан давтлага сургалтыг тогтмол зохион байгуулдаг учраас харамсалтай нь энэ удаа орон нутгийн иргэдийг хамруулах боломжгүй. Төслийн зүгээс материалаа ирүүлсэн бүх хүмүүст талархаж байгаагаа илэрхийлье. 2 дахь удаагийн сургалтын дараа олон чадварлаг сургагч багш нар бэлтгэгдэж гарна гэдэгт итгэлтэй байна.

Багануур дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж сургалт зохион байгууллаа

2018.03.02

3-р сарын 2-ны өдөр Багануур дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) болон Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын тухай лекцэнд хамрагдлаа. Хөгжлийн бэрхшээлийг бие эрхтний үйл ажиллагааны дутагдалтай, чадамжгүй байдал гэж үзэх хүн олон байдаг хэдий ч DPUB төслийн хувьд хөгжлийн бэрхшээлийг нийгмийн саад тотгор гэж авч үздэг. Нийгмийн загварын ойлголтын талаарх тайлбар нь амар хялбар зүйл мэт ойлгогдох нь олон учраас DET сургалтаар дамжуулж хөгжлийн бэрхшээлийн олон асуудлын талаар харилцан ярилцлаа. Улмаар оролцогчид нийгэмд ч гэсэн том асуудал байгаа юм байна гэдгийг анзаарч харж чадлаа. DET сургалт нийтдээ 3 цаг үргэлжилдэг харьцангуй урт сургалт хэдий ч оролцогчид багуудад хуваагдан, олон сонирхолтой дасгал ажлуудыг ажиллаж, хөгжилтэй байдлаар хамрагдсан юм. Энэ дашрамд тус сургалтыг төлөвлөж, мөн холбогдох бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэсэн Багануур дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн Хөгжлийн Хэлтсийн хамт олонд гүн талархал илэрхийлье. Багануур дүүрэг нь хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дүүрэг болохоор зорилт тавин ажиллаж байна. Энэ тал дээр цаашид ч гэсэн DPUB төсөл хамтран ажиллах болно. Багануур дүүргийн иргэдтэй тун удахгүй дахин уулзана гэдэгтээ итгэлтэй байна.



Сургалтанд оролцогчид

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com